

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2015-10-08/**

Ажлын хэсгийн 38 дугаар хуралдаан 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 10.00 цагт Уул уурхайн яамны хурлын зааланд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа, Уул уурхайн яамны СТБГ-ын Уул уурхайн хэлтсийн дарга Д.Дамба, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Зууннаст, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, БОНХАЖЯ-ны ахлах мэргэжилтэн Б.Саран, мэргэжилтэн М.Тулга, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Н.Оюунцэцэг, Авилгатай тэмцэх газрын мэргэжилтэн Г.Сарангэрэл, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Татварын ерөнхий газрын татварын ахлах байцаагч Б.Батчимэг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Ариун суврага хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Монголын Байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Б.Наранцэцэг, Нээлттэй нийгэм форумын менежер, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Транспаренси Интернэшнл байгууллагын зохицуулагч Л.Төр-Од, мэргэжилтэн Д.Мөнхжаргал, Оюутолгой ХХК-ны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Бороо гоулд ХХК-ны татварын нягтлан бодогч П.Болормаа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Арева Монгол ХХК-ны Ц.Энхжаргалыг орлож мэргэжилтэн н.Анжлай, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Ц.Уранцоожийг орлож мэргэжилтэн н.Байгальмаа, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмааг орлож ажилтан н.Баттуяа нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 22 гишүүн оролцож ирц 66 хувьтай байв.

Мөн хуралдаанд Кыргызстан улсын ОУИТБС-ын төлөөлөчид, Дэлхийн банкины ахлах зөвлөх Брайн Ланд, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялагийн иж бүрэн түншлэлийн зөвлөх Ричард Биастош, Кэй Пи Эм Жи ХХК-ийн партнер Эбэрст Марк, дэд захирал Г.Соёлмаа, аудитор Ш.Номуундарь, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг болон Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хурлыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Дэлгэрмаа удирдан явуулав.

Б.Дэлгэрмаа: Ажлын хэсгийн 38 дугаар хуралдаан эхэлснийг мэдэгдье. Хурлын хөтөлбөр, дотоод журмыг уншиж танилцуулав. Хөтөлбөр, дотоод журамд өөрчлөлт оруулах санал байхгүй тул хуралдаанаа эхлүүлэв. Нэгдүгээр асуудлыг ажлын хэсгийн харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа танилцуулна.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ын аймаг, нийслэл, сумын дэд зөвлөлийн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Б.Дэлгэрмаа (ажлын алба): Өнөөдрийн танилцуулгаар 2013-2015 онд орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн болон мэдээллийн эрэлт ба нийлүүлэлт, дэд зөвлөлийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын талаар анхаарах асуудлуудыг танилцуулна. Орон нутагт хэрэгжүүлэх гол үндэслэл нь Засгийн газрын 222-р тогтоолын 13.2, 13.3-т Үндэсний зөвлөл нь тайланг илгээх, сумдад суртчилах, үр дүнг нийтэд мэдээлэх, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас зохион

байгуулж буй ажлын явц, үр дүнг хэлэлцэн тодорхой чиглэл үүрэг даалгавар өгч ажиллах, 222-р тогтоолын 11-т бүх шатны Засаг дарга нарт 5 чиг үүргийг тодорхой заасан байдаг. Үүнд, жил бүрийн ОУИТБС-ын тайланг илгээх, ОУИТБС-ын тайланг олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий дэд зөвлөл байгуулах, хяналт тавих, байгаль орчинтой холбоотой мэдээллийг хэлэлцэх, нийтэд мэдээлэх, сумдад дэд зөвлөх байгуулах гэсэн тодорхой чиг үүргийг өгсөн.

2013 онд бүсийн семинарыг Ховд, Хэнтий, Улаанбаатар, Дархан-уул аймагт зохион байгуулж, 20 аймгийн 600 гаруй төлөөлөгчид хамрагдсан байна. 2014 онд Үр дүнд чиглэсэн дэд зөвлөлийн сургалт, 9 сумын ОУИТБС-ын 3 талт уулзалт өдөрлөгийг зохион байгуулж, үүнд 665 төлөөлөгчид хамрагдан мэдээлэл солилцсон. 2015 онд 3 бүсийн чуулган, 3 сумын болон 1 аймгийн өдөрлөг зохион байгуулж, нийт 7 удаагийн арга хэмжээгээр 13 аймаг, 30 гаруй сумын 667 төлөөлөгчид оролцож, аймаг сумын тус бүрийн ОУИТБС-ын 2100 номыг хэвлэж тараасан. Түүнчлэн Монголиан майнинг сэтгүүл, Германы ОУХА-ны нийгэмлэгтэй хамтран "Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ" байгуулах сургалт зохион байгуулж, 10 аймгийн 47 сэтгүүлчид хамрагдсан.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд 19 аймаг, нийслэл, 14 суманд дэд зөвлөл байгуулсан, нийт 23 удаагийн сургалт, семинараар 21 аймаг, нийслэл, 40 гаруй сумдын 1300 гаруй оролцогч нарт мэдээлэл хийж эргэх холбоотой болсон, дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг баталсан, аймаг сумын тайлан боловсруулалт сайжирсан, судалгааны бааз үүссэн зэрэг тодорхой үр дүнг хүрсэн.(танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа (зөвлөх): За танилцуулга хийсэн ажлын албаны мэргэжилтэн Дэлгэрмаад баярлалаа. Нэмэлт танилцуулгыг Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан танилцуулна. Энэ танилцуулгын дараа асуулт, санал шүүмжлэл байвал тавьж болно.

Н.Баярсайхан: Эрдэс баялгийн салбарт талууд хамтарч ажиллах туршлага, сургамжуудыг авч үзлээ. ОУИТБС-ын хүрээнд 3 талт бүтэц аймаг, суманд байна, мөн Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлийн дагуу гэрээ байгуулахад, олон талууд хамтарч ажиллаж байна, мөн байгалийн нөөцийн үйл ажиллагааг хариуцлагатай явуулах зорилготой Азийн сангийн "Байгалийн нөөцийг ашиглахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд байгуулсан олон талт зөвлөл орон нутагт зохион байгуулагдан ажиллаж байна. Үүнээс харахад Эрдэс баялгийн салбарт талууд хамтарч ажиллах туршлагатай болсон байна, тодорхой сургамжуудыг хуримтлуулсан байна. Энэ гурван талууд хамтарч ажиллахад ямар бэрхшээл тулгарч байна, шийдвэрлэх боломж юу байна гэдэг талаар танилцуулахаар шийдсэн. Ингээд гурван хэлбэрийн олон талт хамтын ажиллагааг танилцуулж тэдгээрийн сургамж, нийтдэг бэрхшээлийг танилцуулж цаашид хэрхэн бэрхшээлийг шийдэх санал танилцуулъя. Нэг. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд олон улсын шаардлагыг хангах талаар талууд идэвхтэй ажиллаж байна. Гэвч үндэсний хууль тогтоомжийг хангалттай баталгаажуулж өгөөгүй учраас санаачилга гэдэг хэлбэрээр хандан, жижиг дунд компаниуд болон зарим орон нутгийн захиргаа ч гэсэн санаачилга юм чинь хэрэгжүүлсэн ч яах вэ гэдэг байр суурьнаас хандах хандлага нилээдгүй байгаа. Бидний үндсэн баримт бол тайлан байгаа, үүгээр хөгжлийн бодлого боловсруулах, авилга бууруулах, ядуурлыг бууруулах, төсвийн болон өрийн бодлогод уг тайланг ашиглаж чадахгүй байгаа нь бидний сургамж юм гэж үзэж байна.Эрдэс баялагийн салбарыг бүхлээр нь ил тод нээлттэй хариуцлагатай явуулах талаар 2013 оноос санаачилга илүү өрнөсөн байгаа. Гэтэл ОУИТБС нь зөвхөн татвар төлбөр, санхүүг ил тод

болгодог гэдэг ойлголт хэвээрээ байсаар байна. Талууд харилцан адилгүй ойлголттой байна. Иргэд болон жижиг компаниудыг эрх мэдэлжүүлэх хэрэгтэй байна. Нийтдээ 1600 гаруй компани үйл ажиллагаа явуулж байгаа, түүнээс аудитад хамрагдаж чадахгүй байгаа 1000 орчим компаниудад чиглсэн бодлого арга хэмжээ хэрэгжүүлж чадахгүй байна. Мөн тайлангаа гаргаагүй болон буруу мэдээлэл гаргаж байгаа компаниудад хариуцлага тооцох механизм байхгүй байна. Иймээс үүднээс-хуулийн төсөл боловсруулан ажиллаж байна. Хоёр. Ашигт малтмалын тухай хуулиар сумдад гэрээ байгуулдаг. Үүнд иргэдийг оролцуулахгүй байгаа, хайгуулын компани гэрээ хийхгүй байна, зөвхөн ашиглалтын компаниуд гэрээ хийж байна, бизнест шударга тэгш хандах зарчим хэрэгжихгүй байна. Гэрээний үр дүнг дүгнэх, хариуцлага тооцох механизм байхгүй байна, иргэдийн оролцоо сул байна, түүнчлэн оролцох аргаа ч мэдэхгүй байх тохиолдол байна. Гэрээний заалтууд оновчтой бус хязгаарлагдмал байдаг, зөвхөн хандив авах, ажлын байр нэмэгдүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байна, Байгаль орчны заалтууд хангалтгүй тусгагдаж байна, гэрээний заалтууд урт нэртэй хуулийн зарим заалттай зөрчилдөж байна. УУЯам болон Засгийн газарт гэрээний загвар боловсруулах ажил явагдаж байгаа ч удаан явцтай байна. Эдгээр нь гурван талууд хамтран ажиллах явцад ажиглагдсан сургамжууд юм. Гурав. Азийн сангийн санхүүжилттэй уул уурхайн салбарт талуудын оролцоог хангах нь хөтөлбөр хэрэгжиж байна, үүний хүрээнд 11 аймгийн 54 гаруй сумдад олон талт зөвлөл ажиллаж байна. Энэ зөвлөлийг төрөөс дэмжсэн ямар нэгэн шийдвэр гараагүй, орон нутгийн ИТХ болон захиргааны оролцоо сул, хамрах хүрээ нь нүсэр байгаа нь зарим газар харагдаж байгаа. Зарим зөвлөл нь хэтэрхий олон хүнтэй байгаа зэрэг сургамжууд ажиглагдсан.

Үүнээс дүгнэлт хийж харахад нэг суманд байгаль орчин, эрдэс баялагийн чиглэлээр хоёр зөвлөл зэрэгцээ ажиллаж байна. Суманд идэвхтэй иргэд цөөн байгаа, дэд зөвлөлүүдэд ажиллаж байгаа хүмүүс болон үйл ажиллагааны чиглэл давхардаж байгаа. Азийн сан олон талт зөвлөлөө маш сайн чадавхжуулсан байгаа учраас бид түүн дээр тулгуурлаад дэд зөвлөлөө аваад явчих боломж харагдаж байна.

Талууд нэгдсэн ойлголт, санаачилгатай оролцоо байхгүй, Түэншлэлийг асуудлыг шийдэх хэрэгсэл гэж харах үнэмшил байхгүй, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, ойлголт мэдлэг, түүнийг хэрэгжүүлэх нөөц нь хязгаарлагдмал, зөвлөлийн үйл ажиллагаа урт хугацаанд тогтвортой байх боломж, таатай орчин орон нутгийн түвшинд бүрдээгүй байна, орон нутгийн орон нутагт санхүүгийн эрх мэдэл хомс байна, зарим сумдад ОУИТБС-ын ажлуудыг санаачилаад хийж байгаа ч санхүүгийн бололцоо байхгүй байна. Санаачилгын тайланг ашиглах чадавх иргэд болоод орон нутгийн захиргааны ажилтнуудад байхгүй, яаж хэрэглэх талаар аргачлал байхгүй байна. Дэд зөвлөл байгуулчихаад яаж ажиллахаа мэдэхгүй зөвлөл ч байна. Үүнээс үүдээд дараахь саналыг дэвшүүлж байна.

1. Дэд зөвлөлийн санхүүжилтийг шийдэх ажлын хэсэг байгуулах,
2. 2016 оныг Дэд зөвлөлийг чадавхижуулах жил болгож ажиллах, төлөвлөгөө боловсруулах,
3. Ажлын албаны зарим чиг үүргийг ТАН эвсэлд гэрээгээр гүйцэтгүүлэх,
4. Орон нутгийн дэд зөвлөлийг чадавхжуулах, загвар дүрэм, журам үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлагнах арга, олон талт хэлэлцүүлэг, компаниудын нээлттэй хаалганы өдөр хийх гэсэн аргачлал заавар журмыг гаргаж өгөх, дэд зөвлөлүүдийн үр дүнг тооцож урамшуулах зэргээр сурталчилах ажлуудыг хийх шаардлагатай байна. Цаашилбал ТАН эвсэл

болон дэд зөвлөл ямар уялдаа холбоотой ажиллах вэ гэдгийг ярилцах хэрэгтэй байна. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Асуулт тавих, санал хэлэх хүн байвал өөрийгөө танилцуулаад хэлж болно. Баярсайхны танилцуулгад олон сайхан санаанууд гарч байна. Үүнийгээ яаж хийхээ сайн тооцоолох нь чухал, түүнчлэн энэ ажлын хэсэгт сайн дураар орж ажиллах хүн байвал нэрээ өгч болно.

Д.Эрдэнэчимэг: Танилцуулгаас харахад 19 суманд дэд зөвлөл байгуулсан гэж байна. Энэ нь өндөр үр дүн мэт харагдаж байгаа ч эдгээр зөвлөлүүдийн үйл ажиллагаа ямар байна, стандартын шаардлагад нийцэж ажиллаж байна уу, тогтмол үйл ажиллагаатай байж чадаж байна уу, тайланг орон нутагт хэрэглэх, иргэдэд суртчилах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлаа эргэж харах хэрэгтэй байна. 2013 оноос дэд зөвлөл байгуулагдсан ч үйл ажиллагааг нь харахад жилийн эцэст тайлан гаргахаас хэтрэхүй байна. Мөн дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд 15 хүнээс 3-аас хэтрэхгүй ИНБ, иргэдийн төлөөлөл орсон байдаг, зарим газар ямар ч төлөөлөл байхгүй байна. Дэд зөвлөлийн санхүүжилт шийдэгдээгүй учраас хичнээн төлөвлөгөө гаргасан ч цаасан дээр үлдэж байна. Иймээс одоо байгуулагдах гэж байгаа ажлын хэсэг өмнө нь байгуулагдсан дэд зөвлөлийн бүтцийг эргэж харах ажлыг оруулах саналтай байна.

Н.Баярсайхан: Өнгөрсөн хугацаанд орон нутагт байгуулсан дэд зөвлөлүүд санхүүгийн ямар эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулж байна вэ?

Б.Дэлгэрмаа (ажлын алба): Бид дэд зөвлөлүүдээс судалгаа авсан. Үүнд 8 аймаг, 6 сум хариу ирүүлсэн байна. Зарим сумдад хэлэлцүүлэг, өдөрлөг хийсэн гэсэн мэдээллийг өгсөн. Санхүүжилтээ тухайн үед нь донор орнууд болон ТАН эвслийн санхүүжилтээр хийсэн байна. Түүнчлэн Сэлэнгэ аймагт Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж өдөрлөг зохион байгуулсан байгаа. 14 сумын дэд зөвлөл гэдэгт ТАН эвслийн байгуулсан дэд зөвлөл орсон байгаа. Дэд зөвлөл байгуулсан тухай шийдвэр нь ирсэн тохиолдолд бүртгэж, сумын дэд зөвлөл байгуулсан тухай ажлын албаны веб хуудсанд мэдээлж байгаа. Цаашдаа жишиг хэдэн суманд талууд хамтарч ажиллах нь үр дүнтэй гэж ажиглаж байна.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Дэд зөвлөлд гурван талын оролцоог тэгш хангахад тухайн сум, орон нутагт ИНБ-ын төлөөлөл байхгүй бол зохиомолоор оруулалтай биш, төвөгтэй юм. Одоо Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудлыг Их Хурлаар хэлэлцэх яригдах гэж байна. Иргэдийн Нийтийн Хурал гэдэг нь өөрөө асар том-иргэний нийгмийн том институт юм. Улс төрийн намууд оролцож байгаа учраас институцын утга учир алдагдаж, иргэдийн оролцооны мөн чанар нь алдагдсан байгаа. Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд оролцохгүй, Засаг дарга нь босоо тогтолцоо руугаа ороод явчихвал энэ асуудал цэгцрэх байх гэж найдаж байгаа.

Н.Баярсайхан: Орон нутагт болж буй хэлэлцүүлэгт компани, орон нутгийн засаг захиргаа өөрийн эх сурвалжаас бэлтгэж байгаа нь ОУИТБС-ын тайлан ашиглалтыг бууруулж гэсэн байна. Энэ яг яаж бууруулж байна вэ? Бид Үндэсний тайлан гарсны дараа хэлэлцүүлэг хийж байгаа, 2 жилийн өмнөх өнгөрсөн хугацааны мэдээллийг хэн ч сонирхохгүй байна гэдэг нь Дорноговийн чуулган дээр ч ажиглагдсан. Тиймээс тодорхой шинэ мэдээлэл орон нутагт хэрэгтэй байна, компаниудын өгч байгаа мэдээлэл нь шинэ аудитлагдсан мэдээлэл

юм.Орон нутгийн захиргааны мэдээлэл ч аудитлагдсан байгаа, яг ямар мэдээлэл нь гамшигт хүргээд байна вэ?

Б.Дэлгэрмаа (ажлын алба): Татварын ерөнхий газар дээр орон нутагт хүлээн авсан орлогыг тайлагнадаг. Аймгийн татварын хэлтсийн нэгтгэж байгаа мэдээлэл нь бүх компаниудын орлогыг нэгтгэдэг харин манайх зөвхөн лицензтэй компаниудын мэдээллийг нэгтгэж байгаагаас зөрүү гардаг. Компаниуд ОУИТБС-ын тайланд хандиваа тусгаагүй мөртлөө суманд очихоор хандивын асуудал гарч ирдэг. Энэ мэтчилэн асуудал гарч байгаа учраас нэгдсэн нэг ойлголтод хүрч, арга зүйгээр хангахгүй бол санаачилгын тайланг жилд нэг удаа бөглөөд өнгөрдөг үүнийгээ орон нутагт ашиглахгүй байна гэсэн санааг хэлсэн.

Н.Баярсайхан: Ойлголоо, ирэх жилийн дэд зөвлөлийг чадавхижуулах жил болгож зарлаад түүнийхээ ажлын хүрээнд орон нутагт тайланг яаж тайлагнах вэ, яаж зохион байгуулах талаар аргачлал боловсруулах хэрэгтэй байна. Орон нутагт 2 жилийн өмнөх тайланг танилцуулах нь ямар ч сонирхолгүй юм.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ОУИТБС-ЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТАД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Г.Ганбат: 2014 оны Үндэсний зөвлөлийн хурлаар маягт өөрчлөх шийдвэр гаргаж, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Б.Болормаагаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тайлангийн маягтыг өөрчлөх ажлаа таван үндсэн багц болгон авч үзсэн. Үүнд, улсын төсөвт хүлээн авдаг орлогод орсон өөрчлөлт, цахим тайлангийн системтэй нийцүүлэх, Олон улсын стандартын дагуу хэрэгжүүлж буй төсөл тус бүрээр гаргах шаардлагад нийцүүлэх, тайлан гаргах хугацааг өөрчлөх болон бусад өөрчлөлт гэсэн чиглэлээр ажилласан. ОУИТБС-ын тайлангийн маягтад оруулах өөрчлөлтийн саналыг танилцуулъя. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Гишүүд ямар саналтай байна.

Х.Лхамаа: Маягтын өөрчлөлтийг заавал өнөөдөр гаргах ёстой юу, бид санхүүгийн хүмүүстэй үзүүлж санал авах хэрэгтэй байх.

Г.Ганбат: Уг нь өнөөдөр шийдвэрээ гаргаад Статистикийн хХороогоор батлуулах ёстой. Бид өнгөрсөн долоо хоногт ажлын хэсгийн гишүүд рүү явуулсан. Оюутолгой ХХК-ны нягтлан бодогч Батбаяр ажлын хэсэгт орж ажилласан байгаа.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Өнөөдөр шийдвэр гарах боломж байна уу, эсвэл саналыг нь авчих юм уу?

Н.Баярсайхан: Маягтын өөрчлөлт хийхэд судалгааг сайн хийсэн байна гэж үзээд би дэмжиж байгаа. Учир нь ТББ-д өгсөн хандив тусламжийг оруулах болж байгаа. Энэ зүйтэй юм, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль гармагц зарим орон нутгийн байгууллагууд ТББ-байгуулаад түүгээрээ дамжуулан хандив тусламж авдаг болсон байна.

Н.Төр-Од: Маягтын 11-р хэсэг дээр сумыг нэмж оруулах санал байна. Мөн 17-р хэсэгт "ТББ иргэнд өгсөн хандив дэмжлэг" гэдгийг хуулийн этгээд гэж өөрчилвөл илүү зохистой байх гэсэн саналтай байна.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Саналыг хүлээн авах боломжтой юу?

Г.Ганбат: Хүлээн авах боломжтой, гэхдээ орон нутгийн тайланд орж байгаа 12 үзүүлэлтэд суманд төлөх төлбөр гэж байхгүй. Түүнчлэн сум тус бүрээр тайлагнавал компаниудад хэтэрхий их ачаалал болох байх. Суманд төлж байгаа орлого гэж байхгүй, суманд татварын хэлтэс гэж байхгүй болохоор сумыг бичих шаардлагагүй байсан.

П.Болормаа: Төлбөр гэдэг нь улсын төсөвт төлж байгаа төлбөрүүдийг хэлж байгаа, тухайлбал газрын төлбөр, ус ашигласны төлбөр нь шууд аймгийн төсөвт ордог. Мөн ТББ, иргэн бусад хуулийн этгээд гэж оруулахгүй бол бусад хуулийн этгээд гэдэгт зөвхөн компанид гэсэн үг юм байна гээд тайлагначих байх иймээс "ТББ, иргэн бусад байгууллага гэж оруулвал илүү ойлгомжтой болох юм гэж бодож байна. Бусад байгууллага гэдэгт хоршоо, нөхөрлөл, сайн дурын нэгдлүүд бүгд орох боломжтой.

Д.Эрдэнэчимэг: Төлбөрүүд аймгийн төсөвт ордог гэж байна, хураамжаас суманд ордог орлого байна уу?

Г.Ганбат: ҮХХ-ийн албан татвар, автотээврийн хэрэгслийн албан татвар газрын төлбөр зэрэг орлогууд ордог ч манай тайланд хураамжууд нь сайн дурын мэдээлэлд ордог.

Н.Баярсайхан: Гадаад иргэдийн ажлын байрны төлбөр суманд орж байгаа.

Б.Батболд: Байгаль орчны барьцаа төлбөрийн 50 хувийн зардал сумандаа ордог учраас "аймаг, нийслэл, сум, дүүрэг" гэж оруулах саналтай байна. Суманд ордоггүй гээд хаяж болохгүй байх, суманд орлого ордог л болоод бид суманд зөвлөл байгуулж байгаа.

Б.Болормаа: Сум руу ордог төлбөр байхгүй учраас "сум" гэдэг үгийг оруулах шаардлагагүй гэж компанийн зүгээс үзэж байна.

Б.Батчимэг: Компани төлбөрөө суманд төлсөн ч гэсэн аймагтаа нэгтгэдэг учраас "сум" гэж оруулах шаардлагагүй гэж төрийн байгууллагын зүгээс үзэж байна.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Тайлагналын хувьд компаниуд яаж тайлагнадаг, Сангийн яам, Татвар зэрэг төрийн байгууллагууд яаж нэгтгэдгийг тусгаад, батлах үед нь саналуудаа тусгаад батлуулахаар боллоо.

| ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Уулсын ОУИТБС-ын 2014 оны тайлангийн явц

Эберт Марк: Юуны өмнө Кэй Пи Эм Жи нэгтгэл ОУИТБС-ын 2014 оны хараат бус аудитын нэгтгэлийн тайланг хийж байгаадаа баяртай байна. Өнөөдрийн илтгэлээрээ анхны зорилт ямар байсан, ажлын үе шатуудын явц ямар

байгаа, энэ жил шинээр юу хийж байгаа, байгууллагуудаа хэрхэн сонгосон болон анхны нэгтгэлийн явц ямар байгаа талаар танилцуулна. (Танилцуулгыг хавсаргав)

Б.Дэлгэрмаа: Эбэрст Маркд баярлалаа. Асуулт, санал байна уу?

Д.Эрдэнэчимэг: Энэ жил эрсдэлд суурилсан хандлагаар компаниудыг сонгож авсан, эдгээр компаниудаас 50 нь тайлангаа өгөөгүй байгаа юм байна. 2015 оны 6 сард ОУИТБС-ын тайлан гаргалт 30 хувьтай байна гэж байсан. Энэ жил цахим тайлангаар авч байгаа нь сайн боловч тайлан гаргалт ямар байна, эдгээр тайлан гаргаагүй 50 компани нь зөвхөн нэгтгэл хийж байгаа компанийн шаардах асуудал биш байх, боломжтой бол ажлын хэсэг, ажлын алба хуулийн дагуу хандаж хариуцлага тооцох ажлыгн хийж болох уу?

Г.Ганбат: Энэ жил цахим тайлангийн системээр 990 компани тайлан гаргасан, Засгийн газрын 1600-аад компани тайлан гаргасан үүнээс 600 компани ОУИТБС-ын тайлангаа гаргаагүй байна.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Эдгээр компаниудад бичиг хүргүүлсэн гэсэн ямар нэгэн хариу байна уу?

Эбэрст Марк: Бид бусад компанийн адилаар эдгээр 50 компаниудад судалгааны маягтаа явуулсан боловч одоогоор хариу ирээгүй байна.

Ричард: Хүлээж авч байгаа мэдээллүүдийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг яаж хангаж байна вэ? Одоогоор хүлээж авсан компаниудын мэдээлэл бүтэн байсан уу?

Эбэрст Марк: Хүлээж авсан санхүүгийн мэдээлэл бүрэн бүтэн байсан, бид нэмэлт мэдээллийн маягтуудыг явуулж байгаа. Энэ жил цахим тайлангаар мэдээллийг авч байгаа, тэдний өгсөн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд явуулсан 1-р маягтандаа энэ мэдээлэл нь танай явуулсан цахим тайлангийн мэдээлэлтэй таарч байна уу гэдгийг гэрчлүүлэн гарын үсгийг авч байгаагаараа давуу талтай юм.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): За мэдээлэл хийсэн Маркд баярлалаа, дараагийн асуудлыг ажлын албаны зохицуулагч Цолмон танилцуулна.

ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын 7 дугаар бага хуралд оролцох тухай танилцуулга

Ш.Цолмон: ОУИТБС-ын Олон улсын 7 дугаар бага хурал 2016 оны 2 сарын 24-25-ны өдрүүдэд Перу улсын нийслэл Лима хотноо зохион байгуулагдана. Бага хурлаар хэлэлцэх асуудалд санаачилгыг хэрэгжүүлж байгаа орнууд өөр өөрийн хэрэгжүүлсэн ажлаа танилцуулж, ололт амжилт, саад бэрхшээл юу байгаа, тэдгээрийг даван туулахад санаачилгыг хэрхэн ашиглаж байгааг сонсож мэдээллээ солилцоно. Уламжлал ёсоор хэрэгжүүлэгч улс орнууд үзэсгэлэн гаргаж, өөрсдийн ололт амжилтаа дэлгэн харуулна.

ОУИТБС-ын олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас хэрэгжүүлж буй гишүүн орн бүрээс 4 төлөөлөгчийн зардлыг хариуцна. Өөрийн байгууллагын зардлаар оролцох төлөөлөгчдийн тоонд ямар нэг хязгаар тогтоохгүй, иймд оролцох төлөөлөгчдийн нэрс, аль төлөөллийн болох, цахим шуудангийн хаяг, гадаад паспортын эхний нүүрийг скайнердан ОУИТБС-ын олон улсын нарийн бичгийн дарга нарийн газарт 10 дугаар сарын 21-ны өдрөөс өмнө тухайн орны ажлын алба хүргүүлсэн байх шаардлагатай учраас явах төлөөлөгчдийн саналыг 2015 оны 10 дугаар сарын 18-наас өмнө хүргүүлэхийг хүсье.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Гишүүд 3 талаас саналаа гаргаад, ажлын албанаас нэг хүн нийт 4 хүн явах юм байна. Зарчмын хувьд хамгийн их санаачилгатай, идэвхтэй хүн явах ёстой, гэхдээ ээлж дараалал байх ёстой. Урьд нь манайхан 2 ч удаа явсан байгаа, иргэний нийгмийнхэн саналаа хэлж, хүнээ гаргаарай бид энэ асуудалд оролцохгүй. Өөрсдийн зардлаар явах хүмүүс нэрээ өгч болно.

Д.Эрдэнэчимэг: Иргэний нийгэм 2 сүлжээ байдаг, ТАН эвслийг төлөөлж гадаад арга хэмжээнд оролцох журам гэж гарсан үүний дагуу бид дотроо ярилцаад 18-ны дотор холбогдох мэдээллүүдийг явуулна. Санаачилгын хэрэгжилтийн хүрээнд Киргиз Монголын Иргэний нийгмийн байгууллагуудын хооронд туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж байгаа. Үүний хүрээнд Кыргызийн дөрвөн төлөөлөгч ирсэн байгаа, дараа нь манай 4 төлөөлөгч Кыргызд ажиллах юм. Өнөөдөр ажлын хэсгийн хуралд оролцож байгаа нь бодит байдал дээр Ажлын хэсгийн хурал яаж болдог, талууд хэрхэн оролцож байгаатай танилцах зорилготой юм. Энэхүү хуралд оролцох бололцоо олгосон ажлын албанд талархлаа илэрхийлье.

Б.Батболд: МБОИЗ-ийн зүгээс ОУИТБС-ын Олон улсын 7 дугаар бага хуралд оролцохгүй гэдгээ мэдэгдэж байна. ТАН эвсэл сайн төлөөлөгчөө томилж, амжилттай сайн оролцоод ирээрэй.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Өмнө хуралд оролцсон төлөөлөгчид яагаад хуралдаа оролцохгүй байна.

Б.Оюун: Газрын тосны үйлдвэрлэлт борлуулалт, тусгай зөвшөөрлийн эздийг хэрхэн ил тод болгож байгаа, газрын тосны кадарстрийн системээ сайжруулж байгаа эсэх, олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар хүргэх талаар танилцуулна гэж ярьлаа. Энэ асуудал манайд тулгамдсан асуудал болоод байгаа, бид энэ асуудлыг судлах, мэдээлэл авах шаардлагатай байгаа тул хурлын төлөөлөгчид газрын тосны газрын төлөөллийг оруулж өгөх болох уу.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Талууд хоорондоо тохиролцоод төлөөллөө сонгоно, ажлын албар энэ асуудалд оролцдоггүй.

ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын үр нөлөөг судлах, Үндэсний чуулганд хэлэлцүүлэх үндсэн илтгэлийг бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай

Ш.Цолмон: ОУИТБС-ын үр нөлөөг судлах, Үндэсний чуулганыг 2015 оны 11 дүгээр сарын 3,4 ны өдөр Улаанбаатарт зохион байгуулах гэж байна. Чуулганы гол илтгэлийн нэг нь ОУИТБС-ын үр нөлөө юу байв, ирэх 5 жилд ямар чиглэлээрр ажиллах тухай үндсэн баримт бичиг боловсруулах, анхаарлаа хааш нь хандуулах, холбогдох зөвлөмж чиглэлийг гаргана гэж үзэж байна. Үндэсний чуулганд танилцуулах илтгэлийг бэлтгэхэд Ажлын хэсэг байгуулах саналтай байна. Ажлын

хэсгийн гишүүдэд Уул уурхайн яамны стратегийн бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннаст, Сангийн яамны НББ-ийн газрын мэргэжилтэн Г.Зулай, Монголын УУҮА-ийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Бороо гоулд ХХК-ын татварын нягтлан бодогч П.Болормаа нарыг оруулах саналтай байна. Иргэний нийгмийн төлөөлөл 2 хүнийхээ нэрийг яаралтай өгөх хэрэгтэй байна.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): За баярлалаа. Одоо Ажлын хэсгийн 38 дугаар хуралдааны шийдвэрийн төслийг танилцуулъя. Шийдвэрийг зөвшөөрч байгаа гишүүд гараа өргөн үү.

Гишүүд 100 хувь зөвшөөрснөөр хурлын шийдвэрийг батлав.

Н.Баярсайхан: 2016 оныг Дэд зөвлөлийг чадавхижуулах жил болгон үүний бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг ажлын албанд даалгав гэж оруулвал яах вэ?

Б.Дэлгэрмаа (зөвлөх): Үндэсний чуулганаар шийдье.

Н.Баярсайхан: За тэгье, дараагийн санал бол 600 компанийг тайлан гаргуулах талаар шийдвэрт оруулах хэрэгтэй байх.

Д.Эрдэнэчимэг: Энэ жил баталгаажуулалтын жил, үүнд бэлтгэх ажлын төлөвлөгөө гарсан, ихэнх ажлууд 9 сарын 24-нөөр хийгдэхээр төлөвлөсөн байсан үүний явц нь ямар байгаа бол?

Ш.Цолмон: Ерөнхийдөө яамдуудаас мэдээлэл ирсэн, гарчихсан байгаа гэж болно.


Г.Ганбат: Ирсэн мэдээллүүдийг веб хуудсанд байршуулж байгаа.

Б.Дэлгэрмаа (зөвлөх): ОУИТБС-ын 38 дугаар хуралдаанд идэвхтэй оролцсон эрхэм гишүүд та бүхэнд баярлалаа. Хуралдааны шийдвэрийг танилцуулж, гишүүд шийдвэрийг батлав. Шийдвэрийг хавсаргав.

Хуралдаан 11:50 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:


Ажлын хэсгийн ахлагч



Б. Дэлгэрмаа

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг

Монголын "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага"-ын Ажлын хэсгийн 38 дугаар хуралдааны шийдвэрүүд

Ажлын хэсгийн 38 дугаар хуралдаан 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдөр (Пүрэв гараг)-ийн 10,00 цагт Уул уурхайн яамны 2 дугаар давхарын хурлын танхимд болов.

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Дэлгэрмаа удирдав. Хуралд Кыргызстан улсын ОУИТБС-ын төлөөлөгчид, Дэлхийн банк, Германы олон улсын хамтын ажиллагааны төлөөллүүд оролцов.

Хэлэлцсэн асуудал:

1. Монгол Улсын ОУИТБС-ын аймаг, нийслэл, сумын дэд зөвлөлийн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай- Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа танилцуулав.

а. Нэмэлт танилцуулгыг Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн, Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн гишүүн Н.Баярсайхан хийв.

ШИЙДВЭР:

- 1.1 2016 онд 4 аймаг, 6 сумын ОУИТБС-ын дэд зөвлөлийг сонгож, чадавхжуулах талаар авах арга хэмжээ авах, үр дүнг Ажлын Хэсэг, Үндэсний зөвлөлд тайлагнахыг Ажлын албанд даалгав;
- 1.2 Аймгийн Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд Засгийн газрын 222-р тогтоолд заасан чиг үүргийг хангаж ажиллах тухай оруулахыг Ажлын албанд даалгав;
- 1.3 Олборлох салбарын суурь мэдээллийг бэлтгэх журам боловсруулж, Ажлын хэсэгт танилцуулахыг Ажлын албанд даалгав;
- 1.4 Дэд зөвлөлийн санхүүжилтын асуудлыг судлах Ажлын хэсгийг Н.Баярсайханаар ахлуулан байгуулж ажиллуулахыг Ажлын албанд даалгах нь зүйтэй гэж үзэв.

2. ОУИТБС-ын тайлангийн маягтад оруулах нэмэлт өөрчлөлт- Ажлын албаны мэдээллийн технологийн зөвлөх Г.Ганбат танилцуулав.

ШИЙДВЭР: Суманд хүлээн авдаг орлогыг Сангийн яамнаас нягтласны дараа нэмэлт өөрчлөлтийг баталж, Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар батлуулахыг Ажлын албанд даалгав.

3. Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны тайлангийн явц-Кэй Пи Эм Жи Франц, Кэ Пи Эм Жи Монголын консорциумын партнер Эбэрст Марк танилцуулав.

ШИЙДВЭР:

- 1.1. Тайлан гаргах ажлыг түргэтгэхийг Кэй ПиЭмЖи түншлэлд хүсч, 11 дүгээр сарын 13-наас өмнө Ажлын хэсэгт урьдчилсан тайланг танилцуулахыг зөвлөмж болгов.
- 1.2. 2014 оны тайлангаа одоогоор гаргаагүй 600 гаруй компаниудаас тайланг гаргуулан ажиллахыг Ажлын албанд даалгав.

4. ОУИТБС-ын 7 дугаар бага хуралд оролцох тухай танилцуулга - Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав.


ШИЙДВЭР: Засгийн газар, Компани, Иргэний нийгмийн өөр өөрийн төлөөллийн нэрсийг 10 дугаар сарын 18-ны дотор Ажлын албанд ирүүлж, 21-ний өдөр Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэхээр тохиролцов.

5. ОУИТБС-ын үр нөлөөг судлах, Үндэсний чуулганд хэлэлцүүлэх үндсэн илтгэлийг бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай - Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав.

ШИЙДВЭР: Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулав. Үүнд:

1. Ажлын албаны зохицуулагч, ахлагч Ш.Цолмон
2. УУЯ-ны стратегийн бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннаст
3. СЯ-ны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай
4. Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд
5. Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч П.Болормаа
6. Иргэний нийгмийн төлөөлөл - Нэрээ өгнө.
7. Иргэний нийгмийн төлөөлөл - Нэрээ өгнө.

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Монголын ОУИТБС-ын Үндэсний
Зөвлөлийн нарийн бичгийн дарга,
Ажлын хэсгийн ахлагч



Б.Дэлгэрмаа